



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар АТДБ

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн
төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах,
чөлөөлөх иргэдийн нэрийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 31 дүгээр зүйлийн 31.2, 31.5 дахь хэсэг, Улсын Их хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоол, 2023 оны 119 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн харьяат хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах иргэдийн нэрсийг нэгдүгээр, мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас чөлөөлөх иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн мөнгөн төлбөрийг хууль, журмын хүрээнд тогтоох, төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж, цэргийн үүргийн биелэлтийг хангуулах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас чөлөөлөгдөх иргэдийн баримт бичгийг бүрдүүлэн шийдвэрлэж ажиллахыг Цэргийн штаб (дэд хурандаа Г.Нямхүү)-т, мөнгөн төлбөрийг холбогдох дансанд төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-т түс түс үүрэг болгосугай.

3.Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт, шалгалт хийх явцад цэргийн албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн нэрийн жагсаалтыг гарган захирамжийн хавсралтад нэмэлтээр оруулж, тухайн иргэдийн мэдээллийг харьяа аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын даргын Цэргийн штабт хүргүүлсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

1226010069